



VIII/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 11



Дотоод худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 8 сард 22.5 хувиар өслөө

Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны эхний 8 сард 16.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.1 (22.5%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд өмнөх оны мөн үеэс шатахууны бөөний худалдаа 27.9 хувиар, жижиглэн худалдаа 18.0 хувиар, хүнс бөөний худалдаа 21.9 хувиар, жижиглэн худалдаа 13.2 хувиар, моторт тээврийн хэрэгслийн сэлбэг эд ангийн жижиглэн худалдаа 14.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Мөн 2021 оны 8 дугаар сард нийт борлуулалт 2.4 их наяд төгрөг болж, өмнөх сараас 25.0 (1.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 1. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН НИЙТ БОРЛУУЛАЛТ¹, жил бүрийн эхний 8 сард


	2018*		2019*		2020*		2021*		2021* I-VIII 2020* I-VIII хувь
	VIII	I-VIII	VIII	I-VIII	VIII	I-VIII	VIII	I-VIII	
	тэрбум төгрөг								
Нийт	1 928.7	12 521.8	2 072.9	14 977.0	1 870.9	13 569.8	2 384.4	16 625.4	122.5
Бөөний худалдаа	722.4	4 505.5	777.0	5 439.5	711.8	4 997.8	905.2	6 382.0	127.7
Жижиглэн худалдаа	1 206.3	8 016.3	1 295.9	9 537.6	1 159.1	8 572.0	1 479.2	10 243.4	119.5

¹ Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн санд үндэслэсэн тооцоо

Худалдааны салбарын борлуулалтын орлогын 38.4 хувь нь бөөний худалдаа, 61.6 хувь нь жижиглэн худалдааны салбарт ногдож байна.

Жижиглэн худалдааны борлуулалтын орлого 2021 оны эхний 8 сард 10.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.7 (19.5%) их наяд төгрөг, бөөний худалдааны борлуулалтын орлого 6.4 их наяд төгрөг болж, 1.4 (27.7%) их наяд төгрөгөөр тус тус өслөө.

ЗУРАГ 1. ХУДАЛДААНЫ НИЙТ БОРЛУУЛАЛТ,
сараар, тэрбум төгрөг



Худалдааны салбарын нийт борлуулалт 2021 оны 5, 6, 8 дугаар сард өмнөх сараас өсжээ.

Энэ оны 8 дугаар сард өмнөх сараас 25.0 тэрбум төгрөгөөр өсөхөд шатахууны жижиглэн худалдаа, машин, тоног төхөөрөмж, тэдгээрийн дагалдах хэрэгсэл,

төхөөрөмжийн бөөний худалдаа, барилгын материалын жижиглэн худалдаа өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Худалдааны салбарын нийт борлуулалтын 83.4 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна. Улаанбаатар хотын худалдааны салбарын борлуулалт 2021 оны эхний 8 сард 13.9 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.6 (22.6%) их наяд төгрөгөөр өслөө.

Өмнөговь, Дархан-Уул, Орхон, Дорнод, Дорноговь, Төв аймгийн худалдааны борлуулалт нь аймгуудын (Улаанбаатар хотыг оруулаагүй) худалдааны борлуулалтын нийт дүнд 50 гаруй хувийг эзэлж байна.

ЗУРАГ 2. ХУДАЛДААНЫ САЛБАРЫН БОРЛУУЛАЛТ, аймгаар, жил бүрийн эхний 8 сард, тэрбум төгрөгөөр



Ойлголт, тодорхойлолт

Худалдааны нийт үйлдвэрлэлд бөөний болон жижиглэн худалдааны байгууллагуудын худалдаж авсан бараа, бүтээгдэхүүнийг борлуулснаас орсон орлого буюу худалдааны нэмэгдэл, ажиллагчдадаа цалингийн оронд олгосон бүтээгдэхүүн, барилга, байшин, машин, тоног төхөөрөмж түрээслүүлснээс олсон орлого, үндсэн бус үйл ажиллагаа (хоёрдогч, гуравдагч салбарын үйл ажиллагааны орлого, туслах чанарын үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зэрэг)-наас орсон орлого, бусад орлого (үндсэн хөрөнгө худалдсанаас орсон орлого, ногдол ашиг, даатгалын нөхөн төлбөр, валютын ханшийн өөрчлөлтөөс олсон орлого орохгүй)-г оруулна.

Худалдааны салбарын нийт борлуулалт

Тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний борлуулалт бөгөөд тайлант хугацаанд худалдааны салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын цэвэр борлуулалтын нийлбэрээр тооцно.



Эх үүсвэр

ҮСХ, Дотоод худалдааны салбарын аж ахуйн нэгж, байгууллагын сарын мэдээ, НӨАТ төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал 4.0

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Л.Энхбаатар
Утас: (976-51)-264797

